

2. Энэхуу Гэрээнд тусгайлан заагаагүй боловч эрхийн туслалцаа узуулэх ажиллагааг хөнгөвчлөхийн тулд хусэлтийг хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хэлээр буюу орос хэлний орчуулгыг бололцоогоор хавсаргана.

Арван нэгдүгээр зүйл

Шуухийн даалгаврыг бурдуулэх

1. Гардуулж өгөхөөр явуулж байгаа бичиг баримт, эрхийн туслалцаа узуулэх тухай даалгавар / цаашид "шуухийн даалгавар" гэж нэрлэгдэх/ нь гарын усэг, шуухийн тамгатай бол өөр баталгаа шаардагдахгүй*

2* Шуухийн даалгаврыг бурдуулэхдээ уг даалгаврыг явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоошсийг удирдлага болгоно*

Арван хоёрдугаар зүйл

Шуухийн даалгаврын агуулга

I# Шуухийн даалгаврын агуулгат даалгаврын утга, даалгавар явуулж байгаа Шуухийн нэр, хэрэгт оролцогчдын овог нэр, тууний эрхэлж байгаа ажил, оршин суугаа газрын хаяг, мөн даалгавар хулээн авч байгаа шуухийн нэрийг бололцоогоор бичнэ.

2. Бичиг бариитыг гардуулах тухай даалгаварт энэ зүйлийн I дэх ангийн заалтаас гадна бичиг баримтыг гардуулах журам туунийг хулээл авагчийн тодорхой хаягийг заана.

3. Байцаан шийтгэх зарим ажиллагааг явуулах тухай шуухийн даалгаварт шуухээр тогтоогдвол зохих хуулийн ач холбогдол бүхий уйл явдлын тодорхойлолтоос гадна шаардлагатай уед хэрэгт оролцогч этгээдийг байцаах асуултыг оруулна.

Шуухийн даалгаврыг биелүүлэх журам

Арван гуравдугаар зүйл

I. Даалгавар хулээн авч байгаа шуух эрхийн туслалцаа